

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Африкийн ямар улсаас Энэтхэгийн далай руу шууд гарч болох вэ? (1 оноо)
A. Ангол B. Алжир C. Чад D. Танзани E. Замби
2. Аль нь Атлантын далайн дулаан урсгал вэ? (1 оноо)
A. Гольфстрим B. Мозамбик C. Бенгель D. Перу E. Курисио
3. Өмнөд тропикийн шугам ямар эх газруудыг дайран өнгөрөх вэ? (1 оноо)
A. Хойд Америк, Еврази, Австрали B. Австрали, Африк, Антарктид
C. Өмнөд Америк, Африк, Австрали D. Өмнөд Америк, Еврази, Африк
E. Антарктид, Өмнөд Америк, Еврази
4. Орхон гол нь Сэлэнгэ мөрний аль гарын цутгал вэ? (1 оноо)
A. Баруун B. Зүүн C. Хойд D. Зүүн дээд E. Цутгал биш
5. Аль нь Пермийн галавт үүссэн нүүрсний орд газар вэ? (1 оноо)
A. Нүүрстхотгор B. Налайх C. Багануур
D. Нарийнсухайт E. Хар Тарвагатай
6. Манай орны өнөөгийн нутгийн газарзүйн төв цэг, хүйс нь хаана байдаг вэ? (1 оноо)
A. Хэнтийн Дадал B. Төв аймгийн Зуунмод C. Өвөрхангайн Бүрд
D. Баянхонгорын Заг E. Өвөрхангайн Хархорин
7. Иргэн А сувилалд эмчлүүлэхээр Аваргатосонгийн рашаан сувиллын газар руу явжээ. Тус рашаан аль аймагт оршдог вэ? (1 оноо)
A. Сэлэнгэ B. Төв C. Сүхбаатар D. Дорнод E. Хэнтий
8. Цэгийн оронд тохирох үгийг хариултаас сонгоно уу. Төрөлжсөн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг толгойлох үйлдвэрт нийлүүлж бэлэн бүтээгдэхүүн хийх үйлдвэрлэлийн хэлбэрийг гэж нэрлэнэ. (1 оноо)
A. Үйлдвэрийн бөөгнөрөл B. Үйлдвэрийн хоршилт
C. Үйлдвэрийн төрөлжилт D. Комбинат E. Үйлдвэрийн цэг
9. Үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсвэл жилд Монгол улсын Д.Н.Б-ий 5-аас дээш хувийг үйлдвэрлэж байгаа болон үйлдвэрлэх боломжтой ордуудыг юу гэж нэрлэх вэ? (1 оноо)
A. Стратегийн B. Ердийн C. Түгээмэл
D. Орон нутгийн E. Холимог
10. Нарийн ноосны хонины үүлдэр аль нь вэ? (1 оноо)
A. Симменталь B. Уулын Алтай C. Өнжүүл D. Хангай E. Сэлэнгэ
11. Манай орны тээврийн салбарт зорчигч тээврээр тэргүүлэх салбар аль нь вэ? (1 оноо)
A. Авто тээвэр B. Агаарын тээвэр C. Ердийн хөсөг
D. Төмөр замын тээвэр E. Усан тээвэр
12. 1кг аргал түлэхэд 2.1 ккал дулаан ялгардаг бол 500 кг аргал шатаавал хэдий хэмжээний дулаан ялгарах вэ? (1 оноо)
A. 105 ккал B. 1050 ккал C. 1050 ккал D. 1100 ккал E. 105 ккал
13. Нар зенитэд (эгц дээрээс тусах) 2 удаа байрладаг хотыг сонгоно уу. (1 оноо)
A. Сингапур (Х.Ө 1°20') B. Лос-Анжелос (Х.Ө 34°)
C. Санкт-Петербург (Х.Ө 60°) D. Буэнос-Айрес (Ө.Ө 35°) E. Рим (Х.Ө 42°)
14. Аль нь хөгжингүй орон дотроо “Өндөр хөгжилтэй орон” гэх бүлэгт багтах вэ? (1 оноо)
A. Словак B. Эстон C. Канад D. Түрк E. Болгар

15. НҮБ-ын албан ёсны хэлэнд багтдаг хэлийг сонгоно уу? (1 оноо)
A. Швед B. Франц C. Итали D. Португали E. Ирланд
16. Төв удирдлага нь өөрийн орондоо байрлаад, салбаруудаа дэлхийн олон улс оронд тараан байршуулсан, олон улсад үйл ажиллагаагаа явуулах томоохон компаниудыг юу гэж нэрлэх вэ? (1 оноо)
A. Эдийн засгийн интеграци B. Олон улсын тээвэр зуучлал
C. Олон улсын худалдаа D. Олон улсын хөдөлмөрийн газарзүйн хуваарь
E. Үндэстэн дамнасан корпорац
17. Христос шашны гол 3 урсгал аль нь вэ? (1 оноо)
A. Католик, Протестант, Үнэн Алдартан B. Католик, Протестант, Мормон
C. Католик, Шинто, Күнз D. Йудэизм, Сикхизм, Католик
E. Үнэн Алдартан, Католик, Сүннизм
18. Өгөгдсөн бүс нутгаас хүн амын нягтшилаар хамгийн сийрэг бүс нутаг аль нь вэ? (1 оноо)
A. Ява арал B. Баруун Европ C. Зүүн Хятад
D. Хойд Америкийн зүүн эрэг E. Австралийн төв хэсэг
19. Цагаан будаа тариалагч гол бүс нутаг аль нь вэ? (1 оноо)
A. Баруун Өмнөд Ази, Ойрхи Дорнод B. Карибын тэнгисийн орнууд
C. Зүүн, Зүүн Өмнөд, Өмнөд Ази D. Зүүн ба Хойд Африк
E. Дундад ба Хойд Ази
20. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. XX зууны 40-өөд оноос эхлэн мэдээллийн технологи болон цөмийн эрчим хүч, сансрын техникийн хөгжил шинэ шатанд гарч нийгмийн харилцаа, үйлдвэрлэл, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнд чанарын хувьсгал хийсэн. Энэ үйл явцыггэнэ. (1 оноо)
A. Аж үйлдвэрийн хувьсгал B. Нийгмийн хувьсгал
C. Нанотехнологийн хувьсгал D. Шинжлэх Ухаан Техникийн Хувьсгал
E. Соёл иргэншлийн хувьсгал
21. Европоос Ази болон Энэтхэгийн далайд гарах дөт зам болсон тээврийн чухал ач холбогдол бүхий далайн сувгийг нэрлэнэ үү. (1 оноо)
A. Киль B. Панам C. Цагаан тэнгисийн D. Их Хятадын E. Суэц
22. Хойд Америк, Баруун ба Хойд Европ, Зүүн Азийн бүс нутагт ихээр илрэх болсон байгаль орчны асуудлыг тодорхойлно уу. (1 оноо)
A. Тропикийн чийглэг ойн талбайн багасалт B. Цөлжилт, ой мод огтлол
C. Хүчиллэг бороо D. Халуун орны биологийн төрөл зүйлийн хомсдол
E. Аль нь ч биш
23. Японд 2011 оны 3 сард байгалийн ямар гамшигт үзэгдэл болсон бэ? (1 оноо)
A. Ойн түймэр B. Газар хөдлөлт, цунами C. Галт уулын дэлбэрэлт
D. Үер E. Хар салхи
24. Салхиар үүссэн рельеф (хотгор гүдгэр)-ийн төрөл аль нь вэ? (1 оноо)
A. Хөөө, шүрэн арал B. Уурхай карьер, ухсан нүх
C. Довцог, элсэн манхан D. Өрх тогоо E. Мөсөн гол, намаг
25. Астрономийн буюу 1 одон орны нэгж (о.о.н)-ийн зайн хэмжээ хэд вэ? (1 оноо)
A. 150 сая км B. 130 сая км C. 170 сая км D. 100 сая км E. 80 сая км
26. Герман хэлний бүлэгт багтах үндэстэн аль нь вэ? (1 оноо)
A. Итали B. Англи C. Франц D. Перс E. Португал

27. Газрын гадаргаас халсан агаар дээш хөөрөх тутам температур нь буурсаар орчныхоо агаартай адил температуртай болох өндрөөр дээд хязгаараа тогтоодог агаар мандлын үе давхаргыг нэрлэнэ үү. (1 оноо)

- A. Тропосфер B. Стратосфер C. Мезосфер D. Термосфер E. Экзосфер

28. Нэг цагийн бүс уртрагийн хэдэн градустай тэнцэх вэ? (1 оноо)

- A. 24° B. 15° C. 360° D. 30° E. 45°


29. Газрын зураг дээр ижил даралтын утгыг холбосон шугамыг юу гэж нэрлэх вэ? (1 оноо)

- A. Изотерм B. Изогон C. Изогипс D. Изобат E. Изобар

30. Эдийн засгийн Баруун бүсийн тулгуур хот аль нь вэ? (1 оноо)

- A. Өлгий, Ховд B. Өлгий, Улиастай C. Улиастай, Ховд
D. Улаангом, Алтай E. Алтай, Өлгий

31. Дараах цэгийн солбицлыг тодорхойлно уу. (1 оноо)



- A. $\Theta\Theta 54^{\circ}30'$, $3Y 93^{\circ}30'$
B. $X\Theta 54^{\circ}30'$, $3Y 93^{\circ}30'$
C. $\Theta\Theta 55^{\circ}30'$, $BY 94^{\circ}30'$
D. $X\Theta 53^{\circ}30'$, $3Y 93^{\circ}30'$
E. $X\Theta 54^{\circ}30'$, $BY 95^{\circ}30'$

32. Нууруудыг орших аймагтай нь зөв тохируулна уу? (1 оноо)

- 1) Хүйсийн найман нуур A. Завхан
2) Хагийн хар нуур B. Хэнтий
3) Тэлмэн нуур C. Өвөрхангай

- A. 1C, 2B, 3A B. 1C, 2A, 3B C. 1A, 2B, 3C D. 1A, 2C, 3B E. 1B, 2C, 3A

33. Зурагт 1-ийн тоогоор тодруулсан Тусгай Хамгаалалттай Газар нутгийн нэрийг зөв сонгоно уу? (2 оноо)



- A. Цамбагаравын Байгалийн Цогцолборт газар
B. Бурханбуудай уулын Байгалийн Нөөц газар
C. Увс нуурын Дархан Цаазат газар
D. Онон Балжийн савын Байгалийн Цогцолборт газар
E. Алтай Таванбогдын Байгалийн Цогцолборт газар


34. Дараах өгөгдлийг уншаад зөв 2 өгүүлбэрийг сонгоно уу. (2 оноо)

- 1) Цайны эх орон бол Хятад, гол үйлдвэрлэгч орон нь Австрали.
2) Кофений эх орон бол Эфиоп, гол үйлдвэрлэгч нь Бразил.
3) Какаоны эх орон бол Мексик, гол үйлдвэрлэгч нь Афганистан.
4) Тамхины ургамлын эх орон Мексик, гол үйлдвэрлэгч нь Хятад.

- A. 1 ба 2 B. 2 ба 3 C. 3 ба 4 D. 1 ба 4 E. 2 ба 4

35. Зураг дээр 6-ийн тоогоор тэмдэглэсэн хилийн боомтыг сонгоно уу.

(2 оноо)




- A. Бургастай
- B. Ярантай
- C. Даян
- D. Шивээхүрэн
- E. Гашуунсухайт

36. Дэлхийн дулааны бүслүүр дэх сэрүүн бүслүүрийн шинжийг тодорхойлно уу? (2 оноо)

- A. Туйл талаасаа хамгийн дулаан сарын 0°C -ийн изотерм бөгөөд өвслөг ургамлын хилтэй давхцана.
- B. Туйл талаасаа хамгийн дулаан сарын $+10^{\circ}\text{C}$ -ийн изотерм бөгөөд модлог ургамлын хилтэй давхцана.
- C. Туйл талаасаа хамгийн хүйтэн сарын 0°C -ийн изотерм бөгөөд хаг хөвдний хилтэй давхцана.
- D. Туйл талаасаа хамгийн хүйтэн сарын -10°C -ийн изотерм бөгөөд ургамал үгүй.
- E. Туйл талаасаа хамгийн дулаан сарын -10°C -ийн изотерм бөгөөд тундрын хилтэй давхцана.

37. Зурагт А үсгээр тэмдэглэсэн уулсын тогтолцоог нэрлэнэ үү?

(2 оноо)



- A. Сийлхэмийн нуруу
- B. Говь Гурван
Сайханы нуруу
- C. Бүрэнгийн нуруу
- D. Булнайн нуруу
- E. Хөх Сэрхийн нуруу


38. Асуултын тэмдгийн оронд байх газарзүйн объектийн нэрийг сонгоно уу.

(2 оноо)



- A. Энэтхэгийн хойг
- B. Арабын хойг
- C. Аляскийн хойг
- D. Апенниний хойг
- E. Скандиновын хойг


39. Монгол орны угсаатан ястнуудын голлон амьдрах нутгийг өнгөт дэвсгэрийн аргаар дүрсэлсэн зурагт 1 ба 2-ын тоогоор ямар ястныг тэмдэглэсэн бэ? (2 оноо)



- A. 1- Дархад, 2- Захчин
 C. 1- Хотон, 2- Торгууд
 E. 1- Өөлд, 2- Үзэмчин

- B. 1- Дөрвөд, 2-Буриад
 D. 1- Барга, 2- Буриад

40. Зургийг ажиглаад 1-ийн тоогоор заасан хавтангуудын хилийг тодорхойлно уу. (2 оноо)



- A. Ойртон нийлж буй хавтангийн хил зааг
 B. Холдон салж буй хавтангийн хил зааг
 C. Шилжин зөрж буй хавтангийн хил зааг
 D. Хавтангийн хөдөлгөөнийг судлах боломжгүй
 E. Хавтангууд хөдөлдөггүй

41. Дараах фото зургуудыг эх газартай нь зөв тохируулсныг сонгоно уу. (2 оноо)



A. Африк

B. Өмнөд Америк

C. Австрали

D. Хойд Америк

A. 1C, 2A, 3D, 4B


B. 1B, 2C, 3A, 4D

C. 1D, 2B, 3C, 4B

D. 1A, 2B, 3C, 4D

E. 1B, 2A, 3C, 4D

42. Байрзүйн зургийн таних тэмдгүүдийг зөв харгалзуулсан хувилбарыг нэрлэнэ үү. (2 оноо)



A.

B.

C.

D.

A. 1C, 2D 3B, 4A


B. 1A, 2D, 3C, 4B

C. 1B, 2D, 3A, 4C

D. 1C, 2D, 3A, 4B

E. 1C, 2B, 3D, 4A

43. Нарны эгц тусгалыг үзүүлсэн тахир шугам дээр A гэж тэмдэглэгдсэн газарт хэдэн сарын хэдний өдөр болж байх боломжтой вэ? (2 оноо)



A. 5 сарын 21


B. 3 сарын 21

C. 6 сарын 22


D. 12 сарын 22

E. 10 сарын 21

44. Америкийн Нэгдсэн Улсаас Шинэ Зеланд хүртэл өгөгдсөн сумны дагуу (А-аас В) ертөнцийн зүг чигийг тодорхойлно уу. (2 оноо)




- А. Зүүн хойд В. Баруун өмнөд С. Баруун хойд D. Зүүн өмнөд E. Зүүн
45. Голын хөндлөн огтлолын талбай 12 м^2 , урсгалын хурд 1.7 м/с бол голын усны зарцуулалтыг олоорой. ($Q=S \times V$) (2 оноо)
- A. $21.4 \text{ м}^3/\text{с}$ B. $20.4 \text{ м}^3/\text{с}$ C. $214 \text{ м}^3/\text{с}$ D. $2.4 \text{ м}^3/\text{с}$ E. $21.04 \text{ м}^3/\text{с}$
46. Зураг дээр 1-ийн тоогоор тэмдэглэсэн улсад эрчимтэй хөгжсөн аж ахуй, үйлдвэрлэл аль нь вэ? (2 оноо)




- A. Электроникс, химийн үйлдвэр, аж үйлдвэрийн робот
 B. Банк санхүү, даатгал, үйлчилгээ
 C. Нүүдлийн мал аж ахуй, цай, оёдол нэхмэл
 D. Алт, алмааз, өнгөт төмөрлөг
 E. Боловсролын үйлчилгээ, тэмээ, уулын аялал жуулчлал

47. Масштабыг томоос нь жижиг рүү дараалуулан бичсэн хариултыг сонгоно уу. (2 оноо)



- A. 1, 2, 3
B. 3, 2, 1
C. 2, 3, 1
D. 1, 3, 2
E. 2, 1, 3

48. Зургийг ажиглаад эдийн засгийн Хангайн бүсэд багтах аймгийг олно уу? (2 оноо)




- A. 1 ба 2 B. 2 ба 5 C. 1 ба 6 D. 1 ба 5 E. 4 ба 5

49. Амьтдыг амьдрах байгалийн бүстэй нь зөв харгалзуулна уу. (2 оноо)

- | | |
|--------------------|--|
| 1. Тайга, ойт хээр | A. Мазаалай, хар сүүлт, хулан |
| 2. Хээр | B. Баавгай, хандгай |
| 3. Говь, цөл | C. Хярс, үлийн цагаан оготно, талын бүргэд |
| 4. Өндөр уул | D. Ирвэс, аргаль, янгир |


- A. 1D, 2B, 3C, 4A B. 1B, 2C, 3A, 4D C. 1C, 2A, 3D, 4B
D. 1A, 2D, 3B, 4C E. 1B, 2D, 3C, 4A

50. Энэ газар өмнөд өргөргийн 20°-т оршдог. Тунадас хаана их унах боломжтой вэ? (2 оноо)



- A. А цэг B. В цэг C. С цэг D. D цэг E. Бүх газар ижил

51. Цэгийн оронд тохирох нэрийг сонгоно уу. Хотгор гүдгэрийн зүсэлт нь эх газрыг Ө.Ө-ийн 30°-ын дагуу баруунаас зүүн тийш огтлон гарсан байна. (2 оноо)



- A. Еврази B. Австрали C. Антарктид
D. Өмнөд Америк E. Европ

52. Сумаар ямар бүтээгдэхүүний экспортын чиглэлийг илэрхийлж байна вэ? (3 оноо)



- A. Цахилгаан бараа B. Байгалийн хий C. Автомашин
D. Ой мод, модон бүтээгдэхүүн E. Хувцас, хүнс

53. А улсын нийт хүн ам 2010 онд 4.550.000 байсан бол 2011 онд 4.650.000 болжээ. Жилийн өсөлт хэдэн хувь болсон бэ? (3 оноо)

- A. 3.45% B. 2.19% C. 2.91% D. 3.54% E. 1.29%

54. Томоохон уулсын системийг оргил, далайн түвшнээс дээших өндөртэй нь зөв тохируулна уу? (3 оноо)

1. Гималай A. 6960 м a. Тубкаль
2. Альп B. 4165 м b. Эверест
3. Анд C. 4807 м c. Монблан
4. Атлас D. 8848 м d. Аконкагуа


- A. 1-Cb, 2-Ac, 3-Dd, 4-Ba
B. 1-Cb, 2-Dc, 3-Ad, 4-Ba
C. 1-Ab, 2-Cc, 3-Bd, 4-Da
D. 1-Db, 2-Cc, 3-Aa, 4-Bd
E. 1-Db, 2-Cc, 3-Ad, 4-Ba

55. Манай орны зарим хотуудын жилд унах хур тунадас, агаарын температур болон гадарга, газарзүйн байрлалыг тодорхойлсон хүснэгтийг ажиглаад асуултын тэмдгийн оронд тохирох хотыг сонгоно уу? (3 оноо)

| Хотууд | Өргөрөг | Өндөр (м) д.т.д | Дундаж температур (t °C) | | | Жилд унах тунадас (мм) |
|------------|-----------|--------------------|--------------------------|-------|---------|---------------------------|
| | | | жилийн | I сар | YII сар | |
| Улаангом | ХӨ 49°58' | 939 | -3.7° | -32° | +16° | 138 |
| Баруун-Урт | ХӨ 46°41' | 981 | +0.6° | -21° | +20° | 203.7 |
| Алтай | ХӨ 46°22' | 2181 | -1.5° | -19° | +14° | 171.2 |
| ? | ХӨ 43°34' | 1465 | +4° | -16° | +21° | 129.5 |

- A. Улаанбаатар B. Сүхбаатар C. Даланзадгад D. Дархан E. Тосонцэнгэл

56. Монгол улсын хүн амын тооллоготой холбоотой тоон мэдээллүүдийг өгөв. Графикт дүрсэлсэн өгөгдлүүдийг ажиглаад өгөгдсөн хариултуудаас үнэн нэг өгүүлбэрийг сонгоно уу? \1000 хүнд ноогдох төрөлт, нас баралт, ердийн өсөлт\ (3 оноо)



- A. Ердийн өсөлт ба төрөлтийн тоо хэмжээ хамгийн бага байсан нь 1944 он.
 B. Ердийн өсөлт 1963 онд хамгийн өндөр түвшинд хүрч, 1956 онд хамгийн бага байсан.
 C. 1956 оны төрөлтийн тоо хэмжээ 1935 оныхоос 3 дахин өссөн.
 D. 2000 оноос хойш төрөлт тодорхой хэмжээгээр өссөн байна.
 E. 1935 онд нас баралтын тоо хэмжээ төрөлтийн хэмжээнээс их байсан.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Анхааруулга

Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны 2-р хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Жишээлбэл, эцсийн хариу 5650 гэж гарсан бол a-5, b-6, c-5, d-0 гэж бөглөнө.

- 2.1. Канадаас ирсэн хэсэг жуулчид Хөвсгөл нуурын эргээр өглөө эрт морин аялал хийхээр болжээ. Аялалын хөтөч өдөртөө агаарын температур $+20^{\circ}\text{C}$ болохыг сануулахад тэд франгейтийн хуваарьт шилжүүлэн хэлэхийг хүсэв. Хөтөч хэд гэсэн хариултыг өгсөн бэ? / $t^{\circ}\text{F} = 9/5 t^{\circ}\text{C} + 32$ / (3 оноо)
- 2.2. Улаанбаатараас Зуунмод хот хүртэл 30 хүний суудалтай автобусанд 2 удаа $\frac{1}{2}$ ээр, мөн 1 удаа $\frac{1}{3}$ ээр нь зорчигч тээвэрлэжээ. Зорчигч эргэлт 1800 хүн*км бол Улаанбаатар Зуунмод хоёрын хооронд хэдэн км зайтай вэ? ($S = Z / H$) (4 оноо)
- 2.3. Тухайн үеийн агаарын температур 30°C , чийгийн багтаамж 30 г/м^3 , харьцангуй чийг 80% байсан бол дутмаг чийгийг олоорой. (4 оноо)
- 2.4. Улаанбаатар (7-р цагийн бүс) хотоос Сүүл (8-р цагийн бүс) хот руу 08 цагт хөөрсөн онгоц Сүүлд тухайн бүсийн цагаар 12 цагт буужээ. Онгоц хэдэн цаг ниссэн бэ? (4 оноо)